



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 448

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагааннуур чөлөөт бүсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 38,000,000.00 (гучин найман сая) төгрөгийн балансын үнэ бүхий 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Цагааннуур чөлөөт бүсийн захирагчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Аманкелдид дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, бүртгэх;

2.4. Худалдсан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2021 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА *Д. Нарангэрэл* Д.НАРАНГЭРЭЛ

132001353

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



**ЦАГААННУУР ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ
АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

| д/д | Суудлын автомашин марк, улсын дугаар | Үйлдвэрлэсэн/ ашиглалтанд орсон он | Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Худалдах доод үнэ (төгрөг) |
|-----|--|--|--|-------------------------------|
| 1 | Тоёота Прадо 62-00 УБП, Арлын дугаар RZJ950031476 | 1999/2008 | 23,000,000.00 | 650,000.00 |
| 2 | УАЗ-Фургон 2206, Улсын дугаар 27-64 УБО, Арлын дугаар 80462395 | 2008/2008 | 15,000,000.00 | 500,000.00 |
| | Нийт дүн | | 38,000,000.00 | 1,150,000.00 |